

БАТЛАВ.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА, НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА *С.АЛТАНЗУЛ*

2019 оны *10* дугаар сарын *10*

ДУЛААН ҮЙЛДВЭРЛЭХ, ТҮГЭЭХ, ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАНГАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛГҮЙ
100 КВТ-ААС ДЭЭШ ХҮЧИН ЧАДАЛТАЙ ХАЛААЛТЫН ЗУУХТАЙ АЖ АХУЙ НЭГЖ
БАЙГУУЛЛАГАД НҮҮРС ТЭЭВЭРЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН
ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН
УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО.

1.1. Байгаль орчин, Аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/433-А/820 дугаар тушаал, захирамжаар батлагдсан "Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөж ажиллах журам"-ын 3.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлгүй 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухтай аж ахуй нэгж, байгууллагуудад Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьяа Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ-аас нүүрс тээвэрлэх зөвшөөрөл олгож байгаа болон тэдгээрийн хэрэгжилт, явц, үр дүнд хяналт шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлт боловсруулж, Хотын Ерөнхий менежерийг мэдээллээр хангахад оршино.

1.2. Эрх зүйн үндэслэл: Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/433-А/820 дугаар тушаал, захирамж, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 19/13 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/933 дугаар захирамжийг тус тус удирдлага болгоно.

ХОЁР. ШАЛГАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА, БҮРЭЛДЭХҮҮН

2.1. Хамрах хүрээ:

2.1.1. Хэсэгчилсэн инженерийн хангамжийн удирдах газар ОНӨААТҮГ /Инженерийн бодлогын алба/:

2.1.2. Нүүрс дамжин өнгөрөх цэгүүд. ХУД-ийн Өлзийтийн пост, СХД-ийн 22-ын товчоо, БЗД, Налайхын пост. /Мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагын хяналт, бүртгэлийн үйл ажиллагаа/

2.1.3. Нүүрс татан авалтын эхлэлийн цэг. /Вагон тээвэрлэлт, буулгалтын цэг дээрх мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагын хяналт, бүртгэлийн үйл ажиллагаа/

2.2. Хугацаа: 2019 оны 10 дугаар сарын 11-нд явуулна.

2.3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

Ажлын хэсгийн ахлагч: УБЗАА-ны Дотоод хяналтын хэлтсийн дарга Ц.Рэгзэдмаа, Гишүүд:

- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүний хяналтын улсын байцаагч Б.Золжаргал,
- Цагдаагийн ерөнхий газрын Хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хүрээлэн буй орчны хяналтын хэлтсийн ахлах байцаагч Т.Уламбаяр, Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын Агаарын бохирдлыг нөлөөлөл, тархалтын загварчлал хариуцсан мэргэжилтэн С.Алтанзул,

Нарийн бичгийн дарга: Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн Б.Лхагвадулам.

ГУРАВ. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЧИГЛЭЛ.

3.1. Дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлгүй 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухтай аж ахуйн нэгж байгууллагад /194/ УБЗАА-аас өгч буй "Нүүрс тээвэрлэх зөвшөөрлийн бичиг"-ийн маягтын дагуу ХИХУГ-ын хяналтын ажилтнууд ААНБ-уудтай гурвалсан гэрээ хийж буй байдал,

3.2. Нөхцөл шаардлагыг хангасан аж ахуй нэгж байгууллагуудтай гурвалсан гэрээ байгуулсан болон тэдгээрт тавьж буй хяналт, бүртгэл,

3.3. УБЗАА-аас өгсөн зөвшөөрлийн бичгийн дагуу зөвшөөрлийн хуудсыг бичиж олгож буй байдал, бүртгэл, хяналт,

3.4. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2019 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 19/13 дугаар тогтоолын 2 дугаар заалтын хэрэгжилт /зөвшөөрлийн бичгийг УБЗАА-аас зөвшөөрсөн ААНБ-уудад үнэгүй олгож байгаа эсэх/,

3.5. Нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс зөвшөөрлийн бичгийг олгож буй байдал, ажлын уялдаа холбоо, /шаардлагатай тохиолдолд дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөлтэй 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухтай аж ахуйн нэгж байгууллагад өгч буй зөвшөөрлийн асуудлыг хамааруулж танилцаж болох/

3.6. НЗД-ын 2019 оны А/933 дугаар захирамжаар батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд "Агаарын чанарыг сайжруулах бүс, түүнд мөрдөж ажиллах журам"-ын 3.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод ажил үүргийн хуваарийг оновчтой зохион байгуулж, ажилтнуудын чиг үүргийг тодорхой зохион байгуулсан байдал, /удирдлага, зохион байгуулалт/,


ДӨРӨВ. ШАЛГАЛТЫН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.


4.1. Шалгалтад хамрагдах байгууллага нь ажлын хэсгийн гишүүдэд шаардлагатай баримт, мэдээ мэдээллийг бүрэн гарган өгч, ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана.

4.2. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн ХИХУГ ОНӨААТҮГ-т ажиллаж, зөвшөөрөл олголттой холбоотой баримт бичгийн бүртгэл, хяналтыг цаас болон цахим хэлбэрээс үзэж танилцана.

4.3. Зөвшөөрөл олголтын мөрөөр нүүрс тээвэрлэлтийн ажиллагаанд зураг авалт хийх байдлаар нүүрс дамжин өнгөрөх цэгүүд болон нүүрс татан авалтын эхлэлийн цэгүүдэд очиж ажиллаж болох ба үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж буй Мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллага, нэгжүүдээс мэдээлэл авах, нотлох баримт гаргуулан авч болно.

4.4. Шалгалтын ажлын үр дүнг ажлын хэсгээс Хотын Ерөнхий менежерт 7 хоногт багтаан танилцуулна.

ХЯНАСАН:
УБЗАА-НЫ ДОТООД ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, АЖЛЫН ХЭСГИЙН
АХЛАГЧ  Ц.РЭГЗЭДМАА
2019 оны 10 дугаар сарын 10

БОЛОВСРУУЛСАН:
НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ОРОН ТООНЫ ГИШҮҮН, АЖЛЫН ХЭСГИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  Б.ЛХАГВАДУЛАМ